



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН АЛБАН ДААЛГАВАР

2026 оны 04 сарын 08 өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

Засгийн газраас шуурхай авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай

Гадаад орчинд үүсэж буй нөхцөл байдал, тодорхой бус байдлаас шалтгаалан Монгол Улсын эдийн засагт үүсэх сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор Монгол Улсын Ерөнхий сайдаас ДААЛГАХ нь:

1. Түлш, эрчим хүчний хомсдол үүсэхээс урьдчилан сэргийлэх чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг холбогдох албан тушаалтанд даалгасугай:

- 1.1. Олон улсын хурцадмал байдлаас нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай болон татварын хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулахыг Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаярт, Сангийн сайд З.Мэндсайхан нарт;
- 1.2. Газрын тосны бүтээгдэхүүний үнийн огцом өсөлтөөс урьдчилан сэргийлэх, шатахууны нөөцийг бүрдүүлэх хүрээнд хувийн хэвшлийн агуулах, нөөцийн савны багтаамж, нөөцийг оновчтой ашиглах төлөвлөгөө боловсруулж, шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдиннямд;
- 1.3. Улсын хэмжээнд хуучирсан, технологийн шаардлага хангахгүй болсон шатахууны агуулахуудад техникийн комисс ажиллуулж дүгнэлт гаргах, дүгнэлтэд үндэслэн тэдгээрийг хүчитгэх, нэмэлт тоноглол хийх замаар агуулахын хүчин чадлыг нэмэх боломжийг судалж, танилцуулахыг Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдиннямд;
- 1.4. Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламжид хадгалагдаж буй газрын тосны дайвар бүтээгдэхүүнийг суллах арга хэмжээг яаралтай зохион байгуулахыг Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдиннямд;
- 1.5. Стратегийн бараа, бүтээгдэхүүний нийлүүлэлтэд зохиомол хомсдол үүсгэхээс сэргийлж, шатахуун импортлогч аж ахуйн нэгжүүдийн агуулахын үлдэгдлийг хянах системийг ашиглалтад яаралтай оруулахыг Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдиннямд;
- 1.6. Газрын тосны бүтээгдэхүүн хадгалах хүчин чадлыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд аж ахуйн нэгжүүдэд шатахуун хадгалах төвлөрсөн агуулахууд

0026890014

байгуулах байршлыг дэд бүтэц, хот төлөвлөлт, хүн амын суурьшилтай уялдуулан төлөвлөж, газрын асуудлыг шийдвэрлэн, уг агуулах руу чиглэсэн төмөр замын салаа шугамын барилга угсралтын ажлыг эхлүүлж, холбогдох арга хэмжээг авахыг Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдинням, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Э.Бат-Амгалан нарт;

- 1.7. Эрчим хүчний компаниудын тарифын алдагдлаас үүссэн санхүүгийн хүндрэлийг богино, дунд хугацаанд даван туулах төлөвлөгөө, мөнгөн хөрөнгийн дутагдлыг шийдвэрлэх талаар Эрчим хүчний зохицуулах хороотой хамтран санал боловсруулж 2026 оны 04 дүгээр сард багтаан Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхийг Эрчим хүчний сайд Б.Найдалаад;
- 1.8. Эрчим хүчний нүүрс олборлогч уурхай болон дулааны цахилгаан станцын үйлдвэрлэл, технологийн хэрэглээнд шаардлагатай шатахуун, мазут, тос, тосолгооны материал, сэлбэг хэрэгслийн нөөцийг бүрдүүлж, хомсдол үүссэн тохиолдолд дээрх байгууллагуудад нэн тэргүүнд нийлүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдинням, Эрчим хүчний сайд Б.Найдалаа, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг нарт;
- 1.9. Газрын тосны бүтээгдэхүүний нийлүүлэлтийг тасралтгүй хангах зорилгоор Оросын Холбооны Улсын төр, хувийн хэвшлийн удирдлагуудтай яаралтай яриа хэлэлцээ хийх, шаардлагатай хэлэлцээр байгуулах чиглэлээр үргэлжлүүлэн ажиллахыг Гадаад харилцааны сайд Б.Батцэцэгт;
- 1.10. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, түүний үндсэн түүхий эдийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэх боомтын тоог нэмэгдүүлэх, тогтвортой нийлүүлэлтийг хангах хүрээнд хөрш орнуудтай тусгайлсан хэлэлцээр байгуулах, тээвэрлэлтийн зохион байгуулалтыг сайжруулах арга хэмжээ авахыг Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдинням, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, холбогдох сайд нарт.

2. Хүнс, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний нийлүүлэлтийг тасалдуулахгүй, тогтвортой хангах чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг холбогдох албан тушаалтанд даалгасугай:

- 2.1. Стратегийн болон гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний нөөц бүрдүүлэх, нийлүүлэлтийг тасалдуулахгүй байхад чиглэсэн арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, хангамж, нийлүүлэлтийн талаарх мэдээллийг 14 хоног тутамд Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ц.Идэрбатад;
- 2.2. Хаврын тариалалтад шаардлагатай түлш, шатахуун, бордоо, таримлын үрийн нөөцийг бүрдүүлэх чиглэлээр яаралтай арга хэмжээ авч тариалалтын бэлтгэл ажлыг шуурхай хангаж, тариалалтыг технологит хугацаанд нь бүрэн гүйцэтгэхэд бүх талын дэмжлэг үзүүлж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ц.Идэрбатад;
- 2.3. Хаврын тариалалтад шаардлагатай 10,000 тонн шатахууныг хямд эх үүсвэрээр хангах ажлыг зохион байгуулахыг Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдинням, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ц.Идэрбат нарт;

- 2.4. Хаврын тариалалтад шаардлагатай түлш, шатахууныг хямд үнээр нийлүүлэх арга хэмжээнд тариалангийн бүс нутгийн байршлыг харгалзан оновчтой зохион байгуулахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ц.Идэрбатад;
- 2.5. Мал, амьтны эм, вакцин, тэжээл, тэжээлийн нэмэлтийн нийлүүлэлтийг нэмэгдүүлж, нөөц бүрдүүлэх, малын эрүүл мэндийг хамгаалах, гоц халдварт өвчний эрсдэлийг бууруулах арга хэмжээг шуурхай, үр дүнтэй хэрэгжүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ц.Идэрбат, Мал эмнэлгийн ерөнхий газар (Б.Батсүх) -т;
- 2.6. Импортын хамааралтай хүнсний бүтээгдэхүүн, бордоо, хаврын тариалалтад шаардлагатай түүхий эдийг улсын хилээр шуурхай нэвтрүүлэхэд чиглэсэн цогц арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ц.Идэрбат, Сангийн сайд З.Мэндсайхан, Гаалийн ерөнхий газар (П.Дэлгэрнаран) -т;
- 2.7. Хүнс, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний гадаад, дотоод тээврийн саатлаас урьдчилан сэргийлэх, саадыг арилгах, тээврийн зардлыг бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ц.Идэрбат, Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан нарт;
- 2.8. “Хөдөө аж ахуйн корпораци” төрийн өмчит хувьцаат компанийн эзэмшилд байгаа түлш, шатахууны нөөцийн агуулахад хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шаардагдах түлш, шатахууны байнгын нөөцийг бүрдүүлж, зориулалтын дагуу ашиглахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ц.Идэрбатад.
- 3. Эм, эмнэлгийн хэрэгслийн нийлүүлэлтийг тасралтгүй хангах чиглэлээр дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг холбогдох албан тушаалтанд даалгасугай:**
- 3.1. Эм, эмнэлгийн хэрэгсэл, вакцин, биобэлдмэл, ариутгал, халдваргүйтгэлийн бодисын нөөцийг бүрдүүлж, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэн цахимжуулж, нийлүүлэлтийн тасралтгүй байдлыг хангах чиглэлээр шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Эрүүл мэндийн сайд Э.Батшугар, Сангийн сайд З.Мэндсайхан, холбогдох байгууллагуудад;
- 3.2. Эм, эмнэлгийн хэрэгслийн импортын бүрдүүлэлтийг түргэвчилсэн горимоор шийдвэрлэх, хилийн нэвтрэх цэгийн хяналтыг сайжруулж, чанар, аюулгүй байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлэхийг Эрүүл мэндийн сайд Э.Батшугар, Гаалийн ерөнхий газар (П.Дэлгэрнаран)-т;
- 3.3. Эм, эмнэлгийн хэрэгслийн зах зээлийн өрсөлдөөнийг хязгаарласан зохицуулалтыг өөрчлөх, эмийн чанар, аюулгүй байдлын хяналтын тогтолцоог сайжруулах арга хэмжээ авахыг Эрүүл мэндийн сайд Э.Батшугарт.
- 4. Бараа бүтээгдэхүүний нийлүүлэлтийг тогтвортой байлгах хүрээнд тээвэр, логистикийн салбарт дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг холбогдох албан тушаалтанд даалгасугай:**
- 4.1. Иргэний нисэхийн тогтвортой ажиллагааг хангах зорилгоор агаарын хөлгийн түлшний нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангаж, шаардлагатай нөөцийг

бүрдүүлэн, агаарын тээврийн маршрут болон агаарын замыг нэмэгдүүлэх боломжийг судалж, танилцуулахыг Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдинням нарт.

5. Бүх шатны төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагааг хэмнэлтийн горимд шилжүүлэн, зардлыг эрэмбэлж, төсөв, санхүүгийн сахилга батыг чангатгах, хэмнэх чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг холбогдох албан тушаалтанд даалгасугай:

- 5.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөр, арга хэмжээний худалдан авах ажиллагааг 2026 оны 05 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгож, гэрээ байгуулаагүй төслүүдийг зогсоох, гэрээ байгуулсан боловч хэрэгжилт удааширсан төслүүдийг эрэмбэлэн, зогсоох арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Сангийн сайд З.Мэндсайхан, нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Х.Нямбаатар, Төрийн худалдан авах ажиллагааны газар (Ц.Батзул)-т;
- 5.2. Урсгал болон 2026 онд шинээр хэрэгжиж эхлэх хөрөнгө оруулалтын зардлыг эрэмбэлж санхүүжүүлэх, тэвчиж болох зардлыг төсвийн сар, улирлын хуваарьт өөрчлөлт оруулж зохицуулалтын арга хэмжээ авахыг Сангийн сайд З.Мэндсайхан, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Б.Энхбаяр нарт;
- 5.3. Монгол Улсын 2026 оны нэгдсэн төсвийн зарлагын санхүүжилтийг төсвийн орлогын бүрдүүлэлт, төрийн сангийн мөнгөн хөрөнгийн удирдлагатай уялдуулан эрэмбэлж санхүүжүүлэх зохицуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Сангийн сайд З.Мэндсайхан, бүх шатны төсвийн захирагч нарт;
- 5.4. Хууль тогтоомжоор үүрэг болгосон эсвэл Засгийн газраас албан ёсны шийдвэр гарснаас бусад бүх төрлийн форум, хурал, баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, салбарын өдөр зэрэг олон нийтийн арга хэмжээг төсвийн хөрөнгөөр зохион байгуулахгүй байх, хурал, сургалт, семинар, зөвлөгөөнийг цахимаар зохион байгуулж, зардлыг бууруулахыг Сангийн сайд З.Мэндсайхан, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Б.Энхбаяр, Төсвийн ерөнхийлөн захирагч нарт;
- 5.5. Гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх, шаардлагатай зардлыг санхүүжүүлэх зорилгоор олон улсын байгууллага болон хөгжлийн түнш орнуудаас санал болгож буй төсвийн дэмжлэгийн зээл авах асуудлыг судалж, хэрэгжүүлэхийг Сангийн сайд З.Мэндсайханд;
- 5.6. Нийгэм, эдийн засгийн ач холбогдол, үр ашиг бүхий гадаад зээллэгийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх төслийн санхүүжилтийн ашиглалтыг холбогдох гэрээ, хэлэлцээрээр тогтоосон хугацаанд ашиглаж, төслийг бүрэн ашиглалтад оруулахад чиглүүлэн төсвийн удирдлагыг хэрэгжүүлэхийг Сангийн сайд З.Мэндсайхан, холбогдох Засгийн газрын гишүүдэд;
- 5.7. Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны 2026 оны төлөвлөгөөнөөс давсан орлогыг Төрийн сангийн нэгдсэн дансанд татан төвлөрүүлэх, нэмэлт

санхүүжилтийн дансаар хийгдэх гүйлгээнд хяналт, хязгаарлалт тогтоох арга хэмжээ авч ажиллахыг Сангийн сайд З.Мэндсайханд;

- 5.8. Шинээр чиг үүрэг болон албан тушаал бий болгохгүй, орон тоог нэмэгдүүлэхгүй байх, өндөр насны тэтгэвэрт гарсан албан тушаалтны сул орон тоонд, нөхөн томилгоо хийхгүй байхыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Б.Энхбаяр, аймаг, нийслэлийн Засаг дарга нар, бүх шатны төсвийн шууд захирагч нарт;
- 5.9. Төрийн байгууллагын бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэгт шинжилгээ хийсний үндсэн дээр чиг үүргийн давхардалтай эсхүл нэг төсвийн ерөнхийлөн болон төвлөрүүлэн захирагчийн харьяанд байгаа чиг үүрэг ойролцоо, харилцан уялдаа бүхий үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа төсөвт байгууллагуудыг нэгтгэхийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Б.Энхбаярт;
- 5.10. Төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах үүрэгтэй харуул хамгаалалт, халаалт дулаан, цэвэрлэгээ, хоол үйлдвэрлэл зэрэг нийтлэг ажил, үйлчилгээг гэрээний үндсэн дээр хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх, төсвөөс санхүүжилттэй боловч өөрийн орлогоор санхүүжилтийн тодорхой хэсгээ бүрдүүлдэг төсвийн байгууллага, улсын үйлдвэрийн газруудыг аж ахуйн тооцоонд шилжүүлэх замаар улсын төсвөөс гаргахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Б.Энхбаярт;
- 5.11. Төсвийн ерөнхийлөн захирагчийн чиг үүрэгт хамаарахгүй болон хуулиар тусгайлан эрх олгоогүй асуудлаар байгуулагдсан үндэсний хороо, зөвлөл, ажлын алба, нэгжийг татан буулгаж, төсөв хэмнэхийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Б.Энхбаярт;

6. Голлох салбаруудад хөрөнгө оруулалтыг татах чиглэлд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг холбогдох албан тушаалтанд даалгав:

- 6.1. Хөрөнгө оруулагчийн гомдол, санал, хүсэлтийг тогтмол хүлээн авч, холбогдох байгууллагуудад уламжлан, дэмжлэг үзүүлэх, хөрөнгө оруулагчийн гомдлыг шийдвэрлэхтэй холбоотой авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаярт;
- 6.2. Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэр байгуулах төслийн хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулах арга хэмжээг зохион байгуулж, үр дүнг Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Б.Энхбаяр, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөх удирдах зөвлөл (Ц.Одхүү)-д;
- 6.3. Алт цэвэршүүлэх үйлдвэрийн төсөлд хамтран ажиллах, хөрөнгө оруулагч, сонирхогч этгээдийг нээлттэй сонгон шалгаруулах бэлтгэл ажлыг зохион байгуулж, үр дүнг Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдиннямд;
- 6.4. Ногоон эрчим хүчний хөнгөн цагааны үйлдвэрлэлийн цогцолбор төслийн бэлтгэл ажлыг хангуулах хүрээнд хөрөнгө оруулагчид дэмжлэг үзүүлэн хамтран ажиллаж, үр дүн, явцын талаар Засгийн газрын хуралдаанд

танилцуулахыг Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдинням, Эрчим хүчний сайд Б.Найдалаа нарт;

- 6.5. Ган үйлдвэрлэлийн цогцолбор байгуулах төслийн хөрөнгө оруулагч, гүйцэтгэгчийг нээлттэй сонгон шалгаруулах бэлтгэл ажлыг зохион байгуулж, үр дүнг Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдиннямд, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөх удирдах зөвлөл (Ц.Одхүү)-д;
- 6.6. Өмнөд бүсийн өсөн нэмэгдэж буй цахилгаан эрчим хүчний хэрэглээг хангах зорилгоор 450 МВт-ын хүчин чадал бүхий Тавантолгойн дулааны цахилгаан станц барих төслийн хөрөнгө оруулалтыг шийдвэрлэхийг Эрчим хүчний сайд Б.Найдалаа, Өмнөговь аймгийн Засаг дарга Н.Энхбат, “Эрдэнэс Монгол” ХХК (Б.Даваадалай), “Эрдэнэс Тавантолгой” ХК (Н.Цэрэнсамбуу) болон эдгээр компаниудын Төлөөлөн удирдах зөвлөлд;
- 6.7. Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжуулан Оросын Холбооны Улсаас Бүгд Найрамдах Хятад Ард Улс руу байгалийн хий нийлүүлэх хоолой барих төслийг хэрэгжүүлэхтэй холбоотой яриа хэлэлцээрийг эрчимжүүлж, явцыг Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаярт;
- 6.8. Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээс эрчим хүч худалдах, худалдан авах гэрээний хэрэгжилтийг хангуулах, гэрээтэй холбоотой үүссэн төлбөр тооцооны асуудлыг шийдвэрлэж, үр дүнг Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Эрчим хүчний сайд Б.Найдалаад;
- 6.9. Сэргээгдэх эрчим хүчний төслүүдэд хөрөнгө оруулалт, техникийн нөхцөл, цахилгаан түгээх сүлжээнд холбох зохицуулалтыг сайжруулах асуудлыг иж бүрнээр судалж, 2026 оны 2 дугаар улиралд багтаан шийдвэрлэж, тус салбарт хөрөнгө оруулалт татах ажлыг зохион байгуулахыг Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр, Эрчим хүчний сайд Б.Найдалаа нарт;
- 6.10. Оюутолгой төслийн хөрөнгө оруулагчтай байгуулсан хувь нийлүүлэгчдийн гэрээнд заасан зээлийн хүүг бууруулах хэлэлцээрийг эрчимжүүлэхийг Сангийн сайд З.Мэндсайхан, Хууль зүй, дотоод хэргийн сайд С.Амарсайхан нарт;
- 6.11. Оюутолгой төслийн менежментийн үйлчилгээний төлбөрийг бууруулах хэлэлцээрийг эрчимжүүлэхийг Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдинням, “Эрдэнэс Монгол” ХХК (Б.Даваадалай)-д.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД



Н.УЧРАЛ